



## ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**АУДИТЫН СЭДЭВ:** АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ

**НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ДҮРЭМ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨН ХУВААРИЛЖ, БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.**

**АУДИТЫН КОД:  
ОРА-2025/105-  
ШТА-НА**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва  
Утас: 70353088  
Цахим хаяг: [purevlkhagvar@audit.gov.mn](mailto:purevlkhagvar@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805  
Цахим хаяг: [buyanundrakhb@audit.gov.mn](mailto:buyanundrakhb@audit.gov.mn)  
Аудитор: Ц.Одгэрэл  
Утас: 70357955  
Цахим хаяг: [odgerelts@audit.gov.mn](mailto:odgerelts@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

Товчилсон үг.....	2
Хүснэгтийн товъёг.....	2
Дүрслэлийн товъёг.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл.....	2
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:.....	2
Аудитын зорилт:.....	2
Аудитын хамарсан хүрээ: .....	3
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:.....	3
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:.....	3
Үндсэн мэдээлэл.....	3
<b>БҮЛЭГ 1. АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ДҮРЭМ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.....</b>	<b>4</b>
1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна. ....	4
1.2 Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна. ....	5
1.3 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.....	6
<b>БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ АЙМАГ, СУМЫН СОНГУУЛИЙН ХОРОО БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГУУД ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....</b>	<b>6</b>
2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	6
2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.....	8
2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна.....	8
Дүгнэлт.....	8
Аудитын тайлан баталгаажуулах тушаал.....	10
Холбогдох байгууллагын санал.....	11

**Товчилсон үг**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МТБ	Мэдээлэл технологийн баг
СНЖ	Сонгогчдын нэрийн жагсаалт
СХ	Сонгуулийн хороо
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

**Хүснэгтийн товъёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Зардлын гүйцэтгэл	4
2	Сумын сонгуулийн хороонд олгосон санхүүжилт	5
3	УБХ-т олгосон санхүүжилт	6
4	Сонгуулийн хороодын зардлын зарцуулалт	7
5	Аймгийн СХ-ны Төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан	8

**Дүрслэлийн товъёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Сонгуульд ажилласан албан хаагчид	4
2	СЕХ-с олгосон санхүүжилт	5
3	УБХ-ийн зардлын зарцуулалт	7

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл****Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны А/44 дүгээр тушаалыг тус тус үндэслэн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийнэ.

**Аудитын зорилт:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг УИХ-ын холбогдох Байнгын хороонд танилцуулж, бусад байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.

#### **Аудитын хамарсан хүрээ:**

Аудитад Орхон аймгийн сонгуулийн хороо, Баян-Өндөр сумын сонгуулийн хороо холбогдох бусад байгууллагуудыг хамрууллаа.

#### **Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

#### **Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах хэрэгжүүлж, аудитор Ц.Одгэрэл төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн, тайланг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, баталгаажуулан, 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

#### **Үндсэн мэдээлэл**

Монгол улсын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан бөгөөд 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар өөрчлөн найруулсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийг Орхон аймгийн сонгуулийн хороо, Баян-Өндөр сумын сонгуулийн хороо, сонгуулийн 3 хэсгийн хороо, 3 мэдээлэл технологийн ажилтан, 3 даамал, 1 нөөц даамал, 3 иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан ажилласан байна.


Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг аймгийн сонгуулийн хорооны төсөвт 62,617.2 мянган төгрөг баталсан байна.

Орхон аймгийн сонгуулийн хорооны Төрийн сангийн 100210022001 тоот харилцах дансны 1 дүгээр гарын үсгийг Сонгуулийн хорооны дарга Ш.Ганболд, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Дуламжав хариуцан гүйцэтгэжээ.

Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны Төрийн сангийн 100210122001 тоот харилцах дансны 1 дүгээр гарын үсгийг Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны дарга Ш.Өлзийбаяр, 2 дугаар гарын үсгийг сонгуулийн хорооны гишүүн Б.Ган-Эрдэнэ нар хариуцан гүйцэтгэсэн байна.

## Дүрслэл 1. Сонгуульд ажилласан албан хаагчид

/хувиар/



Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг Орхон аймгийн сонгуулийн хорооны төсөвт 62,617.2 мянган төгрөг, Улсын бүртгэлийн хэлтсийн төсөвт 4,132.5 мянган төгрөг тус тус баталсан байна.

**БҮЛЭГ 1. АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ДҮРЭМ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.**

**1.1 Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор 2 байгууллагад 66,749.7 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилагдан ирж гүйцэтгэлээр 64,241.9 мянган төгрөгийг зарцуулж 2,507.8 мянган төгрөгийг СЕХ-ны дансанд төвлөрүүлсэн байна.

**Хүснэгт 1. Зардлын гүйцэтгэл**  
төгрөгөөр/

/мянган

№	Байгууллагын нэр	Санхүүжилт	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Орхон аймгийн сонгуулийн хороо	62,617.20	60,109.45	2,507.75
2	Улсын бүртгэлийн хэлтэс	4,132.50	4,132.50	-
	<b>Дүн</b>	<b>66,749.70</b>	<b>64,241.95</b>	<b>2,507.75</b>

СЕХ-с Орхон аймгийн сонгуулийн хороонд санхүүжилт олгох бүртээ төсвийн хуваарь, хуваарилсан төсвийн тайлбар, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.

СЕХ-ноос Орхон аймгийн сонгуулийн хороонд СХ-ны гишүүдийн урамшуулал, НДШ, хоолны зардалд 42,739.2 мянган төгрөг, маягт хэвлүүлэх, шуудан холбоо, бичиг хэргийн зардалд 2,223.0 мянган төгрөг, томилолт, сургалт, сурталчилгаа, унааны зардалд 15,375.0

мянган төгрөг, санал авах байр бэлтгэх, шуурхай багийн зардалд 1,860.0 мянган төгрөг, болзошгүй зардалд 420.0 мянган төгрөг, нийт 62,617.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

**Дүрслэл 2. СЕХ-с олгосон санхүүжилт төгрөгөөр/**

/мянган



СЕХ-ноос нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сумын сонгуулийн хороо, хэсгийн хороод, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан тооцож, хэрэгцээ шаардлагыг үндэслэн зардлыг бодитой тооцоолсон байна.

**1.2 Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.**

Орхон аймгийн сонгуулийн хороо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд 3 хэсгийн хороо байгуулагдан ажилласан байна.

Орхон аймгийн сонгуулийн хорооноос Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд 37,434.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

**Хүснэгт 2. Сумын Сонгуулийн хороонд олгосон санхүүжилт**

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Сумын сонгуулийн хороо	Хэсгийн хороо			Дүн
			12-1-4	12-1-5	12-1-6	
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	24.60	24.60	24.60	24.60	98.40
2	Сургалтын зардал	1,425.00	-	-	-	1,425.00
3	Бичиг хэрэг	150.00	150.00	150.00	150.00	600.00
4	Шуудан холбоо	200.00	200.00	200.00	200.00	800.00
5	Унааны зардал	320.00	640.00	640.00	640.00	2,240.00
6	Санал авах байр бэлтгэх зардал	-	300.00	300.00	300.00	900.00
7	Сурталчилгааны зардал	-	700.00	700.00	700.00	2,100.00
8	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	-	140.00	140.00	140.00	420.00
9	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	28,851.20	-	-	-	28,851.20
<b>НИЙТ ДҮН</b>		<b>30,970.80</b>	<b>2,154.60</b>	<b>2,154.60</b>	<b>2,154.60</b>	<b>37,434.60</b>

Орхон аймгийн сонгуулийн хороо сонгуулийн зардлыг тооцохдоо сумдын хүн амын тоо, хэсгийн хороодын байршил зэргийг харгалзан үзэж хуваарилсан байна.

Баян-Өндөр сумын сонгуулийн хэсгийн хороодын унааны зардлыг хуваарилахдаа хэсгийн хороодын байршлыг харгалзан үзсэн бол бусад зардлыг СЕХ-с баталсан аргачлал, зөвлөмжийн дагуу хуваарилсан байна.

### 1.3 Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжих зардлыг УБЕГ-ын төсөвт 220,910.0 мянган баталснаас Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 4,132.5 мянган төгрөг хуваарилагдсан байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн төсвийг хуваарилахдаа хэсгийн хорооны тоо, сонгуулиар ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны тоо зэргийг харгалзан үзэн хуваарилсан байна.

Батлагдсан төсвийг зардлын зүйл ангиар нэгтгэн харуулбал:

#### Хүснэгт 3. Улсын бүртгэлийн хэлтэст олгосон санхүүжилт /мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Хуваарилах зардлын төсөв
1	Мөнгөн урамшуулал	2,812.50
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх бичиг хэргийн бусад зардал	1,200.00
3	Техник хэрэгсэл тээвэрлэх, турших болон шуурхай багийн зардал	120.00
	<b>Нийт дүн</b>	<b>4,132.50</b>

## БҮЛЭГ 2. БАТЛАГДСАН ТӨСВИЙГ АЙМАГ, СУМЫН СОНГУУЛИЙН ХОРОО БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГУУД ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

### 2.1 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Орхон аймгийн сонгуулийн хороо нь 62,617.2 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 37,434.6 мянган төгрөгийг Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд, хуваарилж, 22,674.8 мянган төгрөгийг зарцуулж 2,507.8 мянган төгрөгийн хэмнэлтийг СЕХ-ны дансанд төвлөрүүлсэн байна. Хэмнэлт үүссэн шалтгаан нь Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-ноос авах, санал тоолох төхөөрөмжийг СЕХ-д буцаан хүлээлгэн өгөх зардлаас 2,907.6 мянган төгрөг, МТБ, даамлын гишүүний холбоо, унааны зардлаас 750.0 мянган төгрөг, шуудан холбооны зардлаас 50.0 мянган төгрөг, томилолтын зардлаас 1,800.0 мянган төгрөг тус тус хэмнэсэн байна.

Дээрх хэмнэлтээс үүссэн 3,000.0 мянган төгрөгийг сурталчилгааны зардалд гүйлгэн зарцуулсан байна.

Баян-Өндөр сумын сонгуулийн хороонд хуваарилсан төсвөөс хэмнэлт үүсээгүй бөгөөд хуваарилсан төсвийг бүрэн зарцуулсан байна. Зарцуулалтыг зардлын зүйл бүрээр дараах хүснэгтээр харуулав.

## Хүснэгт 4. Сонгуулийн хороодын зардлын зарцуулалт

/мянган төгрөгөөр/

№	Зардлын нэр	Аймгийн СХ	Баян-Өндөр сумын СХ	Дүн
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	24.45	98.40	122.85
2	Сургалтын зардал	-	1,425.00	1,425.00
3	Бичиг хэрэг	300.00	600.00	900.00
4	Шуудан холбоо	350.00	800.00	1,150.00
5	Унааны зардал	400.00	2,240.00	2,640.00
6	Санал авах байр бэлтгэх зардал	-	900.00	900.00
7	Сурталчилгааны зардал	3,000.00	2,100.00	5,100.00
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал	3,752.40	-	3,752.40
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	-	-	-
10	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	-	420.00	420.00
11	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	7,963.20	28,851.20	36,814.40
12	МТБ-ийн гишүүн даамлын урамшуулал, хоолны зардал	5,924.80	-	5,924.80
13	Томилолтын зардал	-	-	-
14	Шуурхай багийн зардал	960.00	-	960.00
15	СЕХ-нд буцаан төвлөрүүлэлт	2,507.75	-	2,507.75
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>25,182.60</b>	<b>37,434.60</b>	<b>62,617.20</b>

Сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор УБЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулах зардлын төсөв батлах тухай” А/82 дугаартай тушаалаар Орхон аймгийн УБХ-г 4,132.5 мянган төгрөг хуваарилснаас 4,132.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Зардлын зарцуулалтыг дүрслэлээр харуулав.

## Дүрслэл 3. УБХ-ийн зардлын зарцуулалт

/мянган төгрөгөөр/



## 2.2 Зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

СЕХ-ны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 3 дугаар хавсралтаар сумдын сонгуулийн хороод төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган ирүүлж, аймгийн сонгуулийн хороо нэгтгэн тайлагнасан байна.

*Хүснэгт 5. Аймгийн СХ-ны Төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлан /мянган төгрөгөөр/*

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Хувь
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	123.00	122.85	0.15	99.9%
2	Сургалтын зардал	1,425.00	1,425.00	-	100.0%
3	Бичиг хэрэг	900.00	900.00	-	100.0%
4	Шуудан холбоо	1,200.00	1,150.00	50.00	95.8%
5	Унааны зардал	2,640.00	2,640.00	-	100.0%
6	Санал авах байр бэлтгэх зардал	900.00	900.00	-	100.0%
7	Сурталчилгааны зардал	2,100.00	5,100.00	(3,000.00)	242.9%
8	Саналын хуудас, төхөөрөмж авах, хүргэх зардал	6,660.00	3,752.40	2,907.60	56.3%
9	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	750.00	-	750.00	0.0%
10	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	420.00	420.00	-	100.0%
11	Сонгуулийн хороодын урамшуулал, хоолны зардал	36,814.40	36,814.40	-	100.0%
12	МТБ-ийн гишүүн даамлын урамшуулал, хоолны зардал	5,924.80	5,924.80	-	100.0%
13	Томилолтын зардал	1,800.00	-	1,800.00	0.0%
14	Шуурхай багийн зардал	960.00	960.00	-	100.0%
	<b>Нийт дүн</b>	<b>62,617.20</b>	<b>60,109.45</b>	<b>2,507.75</b>	

## 2.3 Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлсэн байна.

Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан аймгийн сонгуулийн хороонд хуваарилагдсан төсвийг СЕХ-с ирүүлсэн чиглэлийн дагуу сумын сонгуулийн хороонд хуваарилсан байна. Орхон аймгийн сонгуулийн хорооны зардлын зарцуулалтыг аймгийн сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч, Баян-Өндөр сумын сонгуулийн хорооны зарцуулалтыг сумын Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нар харьяа Төрийн санд нээлгэсэн сонгуулийн бүртгэлийн дансанд гарын үсгийн баталгаа гарган хийсэн байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүжилтийг тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн төвлөрүүлэн захирагчдын данснаас шилжүүлсэн бөгөөд зарцуулалтыг төсвийн шууд захирагч, ахлах нягтлан бодогчид 1, 2 дугаар гарын үсгийг зурж Төрийн сангийн хяналтад зарцуулагдсан байна.

Аудитын явцад сонгууль зохион байгуулахтай холбогдуулан гарсан зардлын зарцуулалтын анхан шатны баримт материалтай танилцахад Орхон аймгийн сонгуулийн хороо нь сурталчилгааны зардлаас бусад зардлын тухайд СЕХ-с ирүүлсэн чиглэлийн дагуу, бусад байгууллагын тухайд зарцуулалт хийхдээ дээд шатны төсвийн захирагчдаас ирүүлсэн тайлбар, чиглэлийн дагуу зарцуулсан байна.

### Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг хууль, дүрэм, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.
- Батлагдсан төсвийг аймаг, сумдын сонгуулийн хороо болон бусад байгууллагууд зориулалтын дагуу зарцуулсан байна.

ТАЙЛАН БИЧСЭН: АУДИТОР



Ц.ОДГЭРЭЛ

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.БУЯН-УНДРАХ

## Аудитын тайлан баталгаажуулах тушаал

ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/15

Эрдэнэт

Аудитын тайлан баталгаажуулах  
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулсан зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороо, Баян-Өндөр сумын Сонгуулийн хороо, Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст тус тус хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер (Б.Буян-Ундрах), аудитор (Ц.Одгэрэл) нарт даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.ПҮРЭВЛХАГВА

## Холбогдох байгууллагын санал

**ОРХОН АЙМГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРОО**

Нутгийн удирдлагын ордон, Амарын талбай, Уртбулаг баг,  
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033  
Утас: 99355775.

2025.07.08 № 43

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн  
зардлын тайлангийн дүгнэлтэд саналгүй.

ДАРГА



Ш.ГАНБОЛД